



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
Ж. БАТЭРДЭНЭ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.04.22 № 06/62 ҮАТ-ГАТ

Хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэмжээний хэрэгжилтийн үр
дүнг ирүүлэх тухай.

“Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийх явцад Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар Баянзүрх дүүргийн нутаг дахь Батоникийн цэцэрлэгт хүрээлэнгийн хашаанд Хүүхдийн тоглоомын мини парсад 108.0 сая төгрөгийн нэмэлт ажил хийх ажил төсвийн тухай хуульд батлагдсан боловч энэ ажил хийгдээгүй байна.

Гэтэл Сангийн яамнаас 2013 оны 3 дугаар сарын 25-ны өдөр БОНХЯ-ны хөрөнгө оруулалтын 900017303 тоот дансанд 108.0 сая төгрөгийг шилжүүлж, (СТБХ-ийн дарга Ц.Ариунсанаа, мэргэжилтэн Д.Отгонжаргал гэж бичсэн байгаа боловч хэн нь ч гарын үсэг зураагүй байв) улмаар тус яамнаас мөн оны 3 дугаар сарын 29-ний өдөр Нийслэлийн ЗДТГ-ын 200051301 тоот дансанд 108.0 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Монгол Улсын “Төрийн аудитын тухай” хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ

Улсын төсвийн 2012 оны хөрөнгө оруулалтын тухай хуулиар Баянзүрх дүүргийн нутаг дахь Батоникийн цэцэрлэгт хүрээлэнгийн хашаанд Хүүхдийн тоглоомын мини парсад хийгдэх нэмэлт ажилд зориулж, БОНХЯ-наас Нийслэлийн ЗДТГ-т шилжүүлсэн 108,0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл, үр дүнг Үндэсний аудитын газарт 2013 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор албан ёсоор хариу мэдэгдэхийг Нийслэлийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Э.Ганхүү, ерөнхий нягтлан бодогч О.Солонго нараас ШААРДАЖ байна.

Албан шаардлага

